



**“ЖЕНКО ТУР БЮРО”
ХУВЬЦААТ КОМПАНИ**

Чингисийн өргөн чөлөө, ШХ-43, Баянгол
зочид буудал, Баянгол оффис
Утас: 976-7012-0202 Факс: 976-11321705
И-Шуудан: info@genco-tour.mn
www.genco-tour.mn

2020. 04. 09 № 20/56
тантай _____ - ны № _____

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээ зохион байгуулах тухай

Дэлхий нийтээр тархаад буй шинэ короновирус /covid-19/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын засгийн газрын шийдвэрээр 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон билээ.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 01 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 15 өдөр Шангри-ла худалдааны төвийн Өргөө-3, 4-р танхимд хуралдуулахаар товлосныг хурлын зар хүргэх журмын дагуу мэдэгдсэн билээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан уриалга болон дээрхи нөхцөл байдлыг харгалзан тухайн товлосон өдөр буюу 2020 оны 04 дүгээр сарын 15-ний өдөр “Цахим хэлбэр”-ээр зохион байгуулахаар шийдвэрлээд байна.

ХҮНДЭТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.ЭНХСАЙХАН

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан “Женко тур бюро” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 09:30 цагт цахимаар явагдах болсныг мэдэгдэж байна.

• Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд;

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. ТУЗ-ын үйл ажиллагааны зардлыг батлах;
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
6. ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах;

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр: 2020 оны 3-р сарын 27-ны өдөр

Хувьцаа эзэмшигчид харилцдаг ҮЦК-нараа дамжуулан саналаа өгөх боломжтой бөгөөд саналын хуудсаар санал авах хугацаа 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 15:00 цагт дуусна.

Хувьцаа эзэмшигчид хурлын материал болон хуралд цахим хэлбэрээр хэрхэн оролцож санал өгөх талаар дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комисс болон дараах и-мэйл хаягаар тодруулна уу?

Хурал зохион байгуулах комисс: 70120202, 90981900, 90911900, 88099331

И-мэйл хаяг: info@genco-tour.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС